



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/74

Пионер толгой

**“Эрүүл бэлчээр-Эрсдэлгүй малчны хот”
уриатай сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажил
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 04/06 дугаар хуралдааны шийдвэр, Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ний А/293 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын сэг, зэм устгал, халдваргүйтгэлийн ажлыг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Сэг, зэм устгалын талаар малчид, мал бүхий иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч Э.Сүглэгмаа (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ш.Нархүү (Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

М.Ариунсан (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Б.Бат-Эрдэнэ (Малын их эмч)

С.Цэнд-Аюуш (Малын их эмч)

Б.Лувсаншийрэв (1-р багийн Засаг дарга)

Д.Мөнхчулуун (2-р багийн Засаг дарга)

Д.Болд-Аюуш (3-р багийн Засаг дарга)

Б.Баттулга (4-р багийн Засаг дарга)

Ч.Батцэцэг (5-р багийн Засаг дарга)

Р.Гантулга (Тамгын газрын дарга)

Э.Цэрэнханд (Цэцэрлэгийн эрхлэгч)

Д.Цэцэгээ (Сургуулийн захирал)

Г.Сүхбаатар (Эрүүл мэндийн төвийн дарга)

Б.Бадамцэцэг (Соёлын төвийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга Э.Хас-очир (Мал эмнэлгийн Улсын байцаагч)

642101243

3. Малын сэг, зэм устгал, халдваргүйтгэлийн ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Малын сэг, зэм устгал, халдваргүйтгэлийг багийн түвшинд чанартай зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнахыг Мал эмнэлгийн тасаг (Э.Хас-Очир), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга)-т даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

